

IV. Түүхэн тэмдэглэл, домог яриа

БРИТАНИЙ МОНГОЛЧУУДЫН “МОНГОЛ ОРНЫ
ХӨГЖИЛД - II” ЧУУЛГА УУЛЗАЛТ

Ж.Болдбаатар

Миний бие Кембрижийн их сургуулийн Монгол, өвөр Ази судлалын төвд 2006 оны IV, V сард зочин судлаачаар ажилласан юм. Энэ хугацаанд Элчин сайд Д.Даваасамбуугийн урилгаар Их Британий Монголчуудын “Монгол орны хөгжилд-II” чуулга уулзалтад оролцох завшаан тохиолдлоо.

Элчин сайдын яам Британи дахь монголчуудын “Монгол улсын хөгжилд” хэмээх анхдугаар чуулга уулзалтыг 2005 онд зохион байгуулж, илтгэл, хэлсэн үгийг эмхтгэн “Эх орноо гэсэн сэтгэл” хэмээх ном гаргажээ. Энэ номонд элчин сайдын сэтгэлийн өчил, Британид суралцагч монгол зулуусын илтгэлүүд, мөн нэрт монголч эрдэмтэн Алан Сандерсийн “Миний Монгол сүүлийн дөрвөн арван жилд” хэмээх өгүүлэл орсон байна.

2006 оны V сарын 1-нд болсон энэ удаагийн буюу II чуулга уулзалтад Британид суралцаж буй докторант, магистрант 10 шахам залуу илтгэл тавьж оролцов. Эхлээд элчин сайд Д.Даваасамбуу товч үг хэлж, “Гучин жилийн дараах Монгол улс” хэмээх илтгэл тавьлаа. Тэрбээр: “Хүний амьдралын нэг үеийг 30 жилээр тооцох нь байдаг юм билээ. Нэг үе солигддог гэж үздэг байх аа. Ирэх гучин жилд бидний амьдралд нөлөөтэй, бас сонирхолтой байж болох болов уу гэж үзэж буй цөөн зүйлийн талаар өөрийн санаа бодлыг хэлье. Зарим тоо баримт хувь хүний тооцоо, төсөөлөл тул албан ёсны гэж үзэж болохгүй бөгөөд зарим нь мөрөөдлийн шинжтэй зүйл ч бий” гэж илтгэлийнхээ эхэнд тэмдэглэв.

Б.Золбоо (London Metropoliatan University) “Хөгжиж буй орнуудад үзүүлэх даяаршлын нөлөө” хэмээх илтгэлдээ: Хөгжиж буй орнуудад даяаршил хэрхэн өрнөж буй, түүний эсрэг, сөрөг талууд, Монголын жишээн дээрх зарим тохиолдлуудыг тайлбарлалаа.

Э.Долгион (Вэст Министрийн их сургууль) “Монгол орны хөгжил: нэгэн эриний дотор” хэмээх илтгэлдээ: энэ эринд “Монголын хөгжлийн гайхамшиг”-ийг хамтдаа бүтээн босгох арга, бодомжуудаа илэрхийллээ.

Д.Гантулга (МВА, Манчестер хот) “Монголчуудын өрсөлдөхүйн давуу тал: өнгөрсөн ба ирээдүй” хэмээх илтгэлдээ: “Монголчуудын түүхэн сургамж, өнөөгийн бидний өмнө тулгарч буй бэрхшээлүүд, түүний онцлог, өвөрмөц тал, даван туулах арга замын тухай санал, бодлоо хэллээ.

Б.Соёлмаа (Манчестрийн их сургууль) “Авилгал ба эдийн засгийн хөгжил” хэмээх илтгэлдээ: Авилгалыг олон улсын түвшинд болон эдийн засгийн шинжлэх ухаанд эдүгээ хэрхэн үзэж буй, авилгалтай амжилттай тэмцсэн улс орнуудын туршлага, өнөөгийн Монголын төр болон төрийн байгууллагуудын бүх шатанд үүсэн бий болоод буй авилгалтай үр өгөөжтэй тэмцэх боломжит хувилбаруудын тухай ярьлаа.

Д.Оросоо (Монголын хууль зүйн үндэсний төв) “Тайван жагсаал цуглаан хийх эрх, түүний эрх зүйн үндсийг шинэтгэх асуудал” гэсэн илтгэлдээ: Монгол оронд жагсаал цуглаан болж буй байдал, бэрхшээл, гажуудал, түүний эрх зүйн үндсийг боловсронгуй болгох арга замын тухай санал, бодлоо хэллээ.

Т.Индра (MD, Mres in Public Health, University of Sheffield) “Нотолгоонд тулгуурласан эрүүл мэндийн бодлого” сэдэвт илтгэлдээ: Нотолгоонд тулгуурласан эрүүл мэндийн бодлого гэж юу болох, Монголын эрүүл мэндийн бодлогод энэ арга барилыг хэрэглэх арга боломж, ач холбогдлын тухай илтгэв.

О.Батбаяр (MD, MSc Public Health, University of London) “Бүсдын тамхины утаанд булагдсаар (мансуурсаар) суух уу?” хэмээх илтгэлдээ: Тамхийг олон нийтийн газар татахыг хориглосон хуулийг Ирланд, Шотланд мөрдөн, ирэх оноос Англи хэрэгжүүлэхээр баталсан нь бидний монголчууд шиг дуурайх дуртай хүмүүст шууд хуулж болох нэгэн зүйл биш үү? гэсэн асуудал дэвшүүлжээ.

Д.Бум-Очир (Кембрижийн их сургууль) “Хайлж байгаа дээд Монгол” гэсэн илтгэлдээ: “Нийгэм-соёлын хүн судлал” (Британид Social Anthropolody, Америкт Cultural Anthropolody) юуг судалдаг болох хийгээд энэхүү ухааныг үндэслэн БНХАУ-д оршдог Дээд Монгол үндэстний дунд хийсэн судалгааныхаа үр дүн, гаргалгаанаас танилцуулав.

Д.Цэрэнбат (Энэ чуулга уулзалтын гол зохион байгуулагч) “Хөгжлийг хурдасгах тогтолцоонд: боломжийг ашиглая” сэдэвт илтгэлдээ: мэдээллийн бааз-Цахим өртөө байгуулах, түүний ач холбогдлын тухай ярьлаа.

Чуулга уулзалтад тавьсан илтгэл, асуулт, хариултаас үзэхэд хилийн чинадад ажиллаж, суралцаж буй монголчууд эх орныхоо хөгжил, ирээдүйн талаар сэтгэл ихэд зовниж, ихийг бодож, сэтгэж байдаг юм байна гэсэн сэтгэгдэл төрснөөс улбаалан, эл чуулга уулзалтын тухай товч мэдээ тэрлэж, илтгэлүүдээс төлөөлүүлэн Элчин сайд Д.Даваасамбуу, Вэст Министрийн их сургуулийн Э.Долгион нарын илтгэлийг толилуулж байна.

ГУЧИН ЖИЛИЙН ДАРААХ МОНГОЛ УЛС

Д.Даваасамбуу

Хүний амьдралын нэгэн үеийг 30 жилээр тооцох нь байдаг юм билээ. Энэ эл хугацаанд солигддог гэж зарим судлаачид үздэг. Ирэх гучин жилд бидний амьдралд нөлөөтэй, бас сонирхолтой байж болох болов уу гэж үзэж буй цөөн зүйлийн талаар өөрийн санаа бодлыг хэлье. Зарим тоо баримт хувь хүний тооцоо, төсөөлөл тул албан ёсны гэж үзэж болохгүй бөгөөд зарим нь мөрөөдлийн шинжтэй зүйл ч бий.

Нэг. Улс төр, эдийн засгийн шинэчлэлт

Монгол улсад 1990-ээд оноос үүсч бий болсон өнөөгийн улс төр, эдийн засгийн тогтолцоонд нэг хэсэгтээ зарчмын өөрчлөлт гарахгүй биз ээ. Өөрөөр хэлбэл бүх нийтийн чөлөөт сонгуулиар бий болдог парламентын засаглал, олон намын бүрдэл бүхий улс төрийн тогтолцоо, зах зээлийн эдийн засаг, хувийн өмч давамгайлсан эдийн засгийн харилцаа үндсэндээ хадгалагдана. Ардчилал, эрх чөлөө, хүний эрх, зах зээлийн харилцааг нийгмийн амьдралын бүх салаа мөчирт хэвшүүлэх, иргэдийнхээ ухамсард суулгах, хуулийг дээдлэн дагаж мөрдөх, шүүх засаглалыг баталгаажуулах зэрэг чиглэлээр ихээхэн ажил хийгдэнэ.

Соёлт ертөнцөд ард түмний төлөөлөл, сонгуулиас өөр шалгарсан улс төрийн тогтолцоо алга байна. Гэхдээ дэлхийн хөгжлийн түүхээс үзэхэд хүчтэй дарангуйллын засагтай эсхүл нэгэн намын удаан хугацааны засаглалын үед хөгжлийн манлайд хүрсэн байх нь олонтаа.

Ард түмнийг төлөөлөн төрийн эрх барьж буй Улсын Их Хурлын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, хяналт тавих арга механизмыг бодох шаардлага гарч мэднэ. Өрнөдийн орнуудад дээд, доод танхим байдгийн адил манайд ийм тогтолцоо яваандаа хэрэг болох талтай. Британийн лордын танхимын үйл ажиллагаа сонирхол татаж байна. Тухайлбал, Засгийн газрын ерөнхий сайд,

сайд байсан хүмүүс хийгээд төр, нийгэм, бизнесийн томоохон зүтгэлтнүүд лордын гишүүн болдог. Өв уламжлан суух нь ч бий. Эдгээр хүмүүсийн мэдлэг, ажлын туршлага зэргийг ашиглах ёстой. Британийн лордын гишүүд цалин авдаггүй бөгөөд хуралд суух үедээ тодорхой хэмжээний урамшуулал авдаг, лордын танхимийн шийдвэрийг Британийн парламент буюу доод танхим нь хүлээж авахгүй байх эрхтэй. Лордын гишүүн байна гэдэг нь бас нэр төр, хүндэтгэлийн механизм болж өгдөг.

Монгол Улс ч гэсэн улс, нийгмийнхээ нэр төрэй зүтгэлтнүүдийнхээ санаа бодлыг авах, тэднийг хүндлэх, парламент, засгийн газрын үйл ажиллагаанд дүгнэлт, шинжилгээ хийлгэдэг арга хэлбэрийг бодож болох юм. Чингисийн үеийн хуралдайн хэлбэртэй байж болох талтай. Тодорхой ажил төрөл эрхлээгүй, улс төрийн амьдралаас холдсон зарим улс төрчид, хуучин сайд, дарга нарын санал, бодлыг авах, хүндлэх механизм дутагдаж байх шиг харагддаг. Хуралдайн гишүүн болгож, тэднийгээ нийгмийн амьдралд идэвхтэй ордог болгох арга байж болох юм.

Хоёр. Эдийн засаг одоо ба 2036 онд

Монгол улсын эдийн засаг 2005 онд 6,2 гаруй хувь, 2004 онд 10,4 хувиар өссөн мэдээ гарсан. Инфляци, юмны үнийн өсөлт 10-12 орчим хувьд сүүлийн хоёр жилд эргэлдэж байна. Манай эдийн засагт шууд нөлөө үзүүлдэг бензин шатахууны дэлхийн зах зээлийн үнэ 2 гаруй дахин нэмэгдэж, дарамт үзүүлснийг бодолцоход үнийн өсөлт харьцангуй тогтвортой байна гэж хэлж болох юм.

Нэг хүнд ногдох орлого буюу мэргэжлийн хүмүүсийн ярьдгаар дотоодын нийт бүтээгдэхүүн 720 ам доллар гарч байна. Үүний худалдан авах чадвараар нь өөрөөр хэлбэл олон улсын хэмжээнд зэрэгцүүлэх үнийн түвшинд оруулан тооцон үзвэл дээрх 720 ам доллар 2,0-3,0 мянган доллар болно. Манай барааны үнэ хөгжингүй орнуудынхтай харьцуулахад 3-5 дахин хямдхан гэсэн санаа.

Улсын хэмжээний албан ёсны статистикт хамрагдахгүй далд орлого нийтдээ 30-40 хувийг эзэлдэг. Үүнийг дээрх орлогод нэмж тооцоход 1,0 мянга орчим болно гэсэн үг. Энэ бол бас л ядуу, хүнд байгааг харуулж байна. Бид 2036 онд одоогийн яригдаад байгаа Оюу толгойн зэс, алтны ордыг 2008-2009 оноос ашиглана гэж үзээд түүнээс эдийн засагт оруулах хувь нэмрийг оруулсны дараа эдийн засгийн өсөлтийг жилд дунджаар 7 хувиас доошгүй байлгасан нөхцөлд нэг хүнд ногдох орлого 2036

онд 10,0 мянган ам доллар, дотоодын нийт бүтээгдэхүүн 40,0 тэрбум ам долларт хүрэх барагцаалсан тооцоо гарч байна.

Дэлхий дахины эдийн засаг дундажаар 3-5 хувь, түүний дотор Азийн орнуудынх 6 орчим, Хятадынх 8-9 орчим хувийн өсөлттэй байх тооцоотой байна.

Гурав. Суурь хийгээд стратеги чиглэл

Далайд гарцгүй, хоёр том орны дунд оршдог. Зэс, алт болон мал аж ахуйн гаралтай ноолуур зэрэг цөөн нэрийн бүтээгдэхүүнээс хамааралтай эмзэг эдийн засаг. Эдгээр нь манай давуу тал болж байна. Хятадын эдийн засгийн өсөлтийг дагасан эрэлт голлох нөлөөтэй болж байна.

Стратеги чиглэл:

- Экспортын баримжаатай эдийн засгийг хөгжүүлэх, тээврийн зардал багатай, үнэ өртөгт нь нөлөө бага үзүүлдэг, дотоодоос түүхий эдээ голлон хангах боломжтой үйлдвэрлэлийг эрчимжүүлэх нь чухал зорилт билээ. Монгол улс үйлдвэржиж хөгжихийн гадаад орчин нэн чухал. Энэ талаар зарим санаа тайлбар хэлье.

Монголын экспортын барааг Европын холбооны орнуудад гаалийн татваргүй оруулах болсныг дээд зэргээр ашиглах, ийм хөнгөлөлтийг АНУ, Япон болон Өмнөд Солонгос хийгээд хоёр хөршөөсөө авахын төлөө хүчин чармайлт гаргах хэрэгтэй байна.

Ийм хөнгөлөлт авах эрх зүйн орчныг олон улсын хүрээнд, тухайлбал Дэлхийн худалдааны байгууллагын шугамаар хийгдэж буй Дохагийн шатны хэлэлцээний үр дүнгээр гарах бичигт тусгуулах шаардлагатай байна. Чингэхдээ Монгол улсын далайд гарцгүйн хүндрэл, эдийн засгийн эмзэг байдал, ядуу зүдүү амьдрал, ардчилал, чөлөөт зах зээлийг хөгжүүлэх талаарх ололт зэргийг харгалзаж байхыг олон улсын эрх зүйн баримт бичигт тусгуулах явдал юм. Энэ байдлыг Европын холбоо хүлээн зөвшөөрч, бидэнд гаальгүй статус олгосныг ашиглаж, дэлгэрүүлэх нь чухал болно.

Манай хөрш БНХАУ бол Дэлхий дахинаа үйлдвэрлэл явуулах талаарх хамгийн том өрсөлдөгч гэдгээ харуулж, түүнийг олон улсын хүрээнд зөвшөөрч байна.

Монгол улс Хятад улстай хөл зэрэгцэн хөгжих, түүнтэй үр ашигтай худалдаа арилжаа явуулахын тулд Дэлхийн томоохон гол зах зээлүүдээс худалдаа, хөрөнгө

оруулалтын тааламжтай орчин, гаальгүй статус авах нэн чухал болохыг дахин тэмдэглэхийг хүсч байна.

- Монгол улсын хөгжил, бидний амьдралд онцгой нөлөө үзүүлж болох уул уурхай, ашигт малтмал, транзит тээвэр, аялал жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн стратеги, хөгжлийн чиглэлийг байнгын анхааралдаа байлгаж, баяжуулан, нарийвчлан тодотгож, ажил хэрэг болгох, үр дүнтэй хэрэгжүүлэх явдал билээ.

- Мал аж ахуй, гар урлал, хөнгөн аж үйлдвэрлэл, мэдлэг боловсролд тулгуурласан үйлдвэрлэл, бүх төрлийн үйлчилгээний салбарыг хөгжүүлэхдээ эхний ээлжинд ажлын байр бий болгох, иргэдийн амьдралын наад зах хэрэгцээг хангахад илүүтэй анхаарч, улс даяар өргөн хүрээтэй далайцтай ажлыг техникийн боловсролын сургалтаас эхлээд байгаль орчин, хөрс газраа хамгаалах хүртэлх амьдралын бүх салаа мөчирт зохион байгуулах шаардлагатай нь харагдаж байна. Санаж, сэдвэл гар доор чинь боломж, ажлын байр, амьдрах эх үүсвэр чинь байна гэдэг юм билээ. Хэт ядуурал, нийгмийн эмзэг хэсэг олшрох нь тогтворгүй байдлыг үүсгэнэ. Үүнээс сэргийлэх гол арга нь ажлын байрны хангамж гэх юм билээ.

- Хуримтлал, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих гол чиглэл, стратеги болно. Зөв менежмент удирдлагын ухаан хэрэгтэй болно. Удирдлагын ухааны хувьд иргэдийн санал, санаачилга, сонирхолыг дэмжих, мөнгөний үнэ цэнийг мэдүүлж, хуримтлал бий болгох, үндэсний мөнгөн тэмдэгтийг үнэгүйдэлгүйд хүргэж болох аливаа алхмаас үүрд салах явдал болно. Хуульчлах. Бидэнд Япончууд, Хятадууд, Солонгосчууд шиг хуримтлал бий болгоход юу саад болоод байгааг олж тогтоох, хуримтлалд тулгуурласан санхүү, зээлийн механизмыг илүү урамшуулах нь зүйтэй биз ээ.

- Ус, эрчим хүчний ирээдүйн хангамжийн балансад дорвитой судалгаа хийх шаардлагатай. Хотжилт явагдаж, нийтийн хэрэгцээний ус хангамжийн талаар аюул гамшиг гарах талтайг анхаарлаас холдуулж болохгүйг төр засаг маань илүүтэй анхаарах учиртай. Үндэсний аюулгүй байдлын асуудал болно.

Дөрөв. Хүн ам

Хүн амын судалгаанаас үзэхэд Монголын хүн ам 1950-1990 оны хооронд 3 дахин өссөн юм билээ. 1990-ээд оноос эхлэн жил тутам хүн амын өсөлт буурсан бөгөөд амьдралын боломж, эх орны хөгжил, ирээдүйн итгэлээс хүн амын өсөлт хамаардаг бололтой. Сүүлийн үед бага зэрэг сэргэх хандлага байгаа боловч баттай

сэргэлээ гэх үндэс алга байна. 2036 оны үед гэхэд хүн ам нэг саяар нэмэгдэж, 3,6 сая болох тооцоо байна.

Тав. Малчид

Даяарчлал, глобалчлалын эринд Монголын малчид, нүүдэлчдийн хувь заяа ямар байх вэ гэдэг нь гадна, дотныхны анхаарлыг татдаг бололтой. Надаас нүүдэлчний амьдралын хэв загварын одоо ба ирээдүйг асуугаад байдаг юм. Монгол түмэн мал аж ахуйгаа эрхлэн амьдралаа залгуулах нь олон мянган жилийн түүхтэй бөгөөд цаашдаа, үүрд байх болно гэж хариулах дуртай. Манай мал аж ахуй бол Монголын бэлэг тэмдэг, тусгаар тогтнолын бааз, баталгаа байх ёстой билээ. “Хүнд” цаг ирвэл биднийг мал дагавал ам тосдоно гэдэг шиг мал аж ахуй аврах болно. Монголын асар уудам нутаг, түүний ихэнх хэсэгт тариа будаа, ногоо, жимс тариад байх боломж хязгаарлагдмал, хот тосгоноор дүүргэх хүн ам, ус, хөрс зэрэг геологийн нөхцөл бас байхгүй. Ийм болохоор уламжлалт мал аж ахуйгаа хөгжүүлэхээс өөр арга байхгүй болов уу. Өнөөдөр албан ёсоор 30,0 сая малтай гэж байгаа. Малчид, мал аж ахуй эрхлэгчидтэй уулзаж, ярилцаж байхад цөөн мал цаана нь дарсан байдаг. Ингээд бодоход гучин сая давсан мал бий байх аа. Үүнээс илүү мал байлгана гэвэл манай хөрс дийлэхгүй, нимгэн, хүн малын хөлд амархан муудна. Эдгээр малыг агуулж, хариулж харж байх малчид бидэнд хэрэгтэй. Мал аж ахуй дээр өнөөдөр 380,0 мянган хүн ажиллаж байгаа бөгөөд энэ тоо 30 жилийн турш хэвээрээ буюу бага зэрэг өсөж 410,0 мянга болох тооцоо байна. Хөгжлийн жаягийг дагаж, соёлын үр малчны амьдралд илүүтэй нэвтэрнэ биз ээ. Наад зах нь моторт хөлөг, телевиз радио, утас холбоо, гэрэл гэгээ илүүтэй ойртох байх аа. Мал сүргийн хувьд Монголын газар хөрс хийгээд зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үүлдэр угсааны өөрчлөлт гарч, сүргийн бүтцэд өөрчлөлт орно байх. Хөрс, ус бэлчээрийн боломжтой газруудад хагас нүүдлийн шинжтэй мал аж ахуйн сектор бий болно. Гэхдээ ихэнх малчдын хөдөөнийхний нүүдэлчний шинж төрх 30 жилийн дараа хадгалагдаж болно гэж үзэж байна. Учир нь хөрс хамгаалах, хүрээлэн байгаа орчны үржил шимтэй байлгахын тулд буудал сэлгэсэн амьдрал хэрэгтэй байх болно.

Зургаа. Аялал жуулчлал

Монголын хөгжлийн нэгэн мотор бол аялал, жуулчлал байх боломж бий. Энэ салбар эрүүл мэнд, хүний аюулгүй байдал, улс төр, нийгмийн дүр төрх Монголд ямар байхаас гадна манай хоёр хөршид ямар байхаас ихээхэн хамаардаг эмзэгт

тооцогддог. Жуулчны тоо саарс-ханиад гарснаас бусад сүүлийн жилүүдэд жил бүр 20-иос дээш хувиар өсч хагас саяд дөхөж, үндэсний орлогод 5-аас дээш хувийг эзлэх боллоо. Ийм маягаар өсөөд байвал манай хүн амтай тэнцэх жуулчид 10 хүрэхгүй жилийн дотор ирдэг болно. Бэлэн бус байдалд олон хүн ирэх нь үйлчилгээнд ачаалал өгч, аялал жуулчлалын нэр хүнд унах эрсдэлтэй. Бидний ирээдүйн чадавх боломжийг төсөөлж үзэхэд дунджаар 10 хувийн өсөлттэй байж чадвал 30 жилийн дараа 4 сая орчим аялагчид Монголд очиж, Монголын эдийн засгийн хөгжилд 20 орчим хувийн нэмэр оруулдаг болох тооцоо хийж болно. Хувийн салбарынхан, аялал жуулчлал эрхлэгчид зочид буудал, хоол хүнсийг яаж ийгээд хангана биз ээ.

Харин хүрээлэн байгаа орчноо хамгаалах, загас, ан амьтны үржил, нөхөхүйд чиглэсэн, нарийн тооцож боловсруулсан бодлого, стратеги хэрэгтэй болно.

Долоо. Транзит

Монголын хөгжилд транзит үйл ажиллагаа томоохон үүрэг гүйцэтгэх магадлалтай. Монгол улс өнөөдөр төмөр зам, агаарын тээврийн транзитаар чамгүй орлого олж, үйл ажиллагаа явуулж байна. Сүүлийн 5-6 жилд ОХУ-аас газрын тос Хятад руу гарч, төмөр замыг сэргээж тогтворжуулахад чухал үүрэг гүйцэтгэж байна. Манай нутгийн агаар мандлаар олон зуун онгоц нисэн өнгөрч, бид түүнээс зохих шимтгэл хөлс авч байна. Төмөр зам, агаарын транзитын дамжуулан өнгөрүүлэх хүчин чадал, үйлчилгээний чанарыг сайжруулахын төлөө хүчин зүтгэл гаргаж байгаа бөгөөд Япон тэргүүтэй донорууд илүүтэй анхаарал тавьж байгаа. Манай хоёр талаар буюу нутгийн зах үзүүрийн хэсгийн богино зайгаар өнгөрөх боломж бас бий. Манай дээгүүр зөвхөн нисээд өнгөрөх биш, бас бууж, мордоод, сонирхоод явдаг болгох сонирхол, аюулгүй, найдвартай орчин бүрдүүлэх нь чухал. Улаанбаатарын орчимд барихаар яригддаг буулт, суултын орчин сайтай онгоц буудал чухал болно. Нэг талаас Зүүн Ази, Алс Дорнод, Австрали тив, нөгөө талаас Европын хооронд бууж мордоод гарах цэг нь 30 жилийн дараа Монголын тал нутаг байхыг хүсэн мөрөөдөж байна. Болохгүй гэх газаргүй агаад энэ чиглэлийн мэргэжилтнүүд хэрэгтэй болно.

Хоёр хөршөө ойрын 10 жилийн дотор авто замаар, дараагийн хорин жилийн дотор нефть, байгалийн хоолойгоор, түүний дараагийн 10 жилийн дотор цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн шугамаар холбох боломж бий болгохын төлөө зүтгэж,

зам харилцааны нэгдсэн системтэй болж, Евро-Азийн их газрын нэгдсэн сүлжээнд Монгол оролцох болно. Нэлээд олон нь Монгол улсын нутгаас эхлэлтэй ОХУ-ын гол мөрнүүдийн усны нөөцийг бүс нутгийн эрчим хүч, цахилгааны хэрэглээг хангах буюу хангах асуудал 30-н жилийн дараа чухлын чухал асуудал болох шинжтэй байна. Нефть, газрын тосны нөөц алсаараа багасгах, хангамж нийлүүлэлт нь улс орнуудын хоорондын улс төр геополитикийн хөзөр болж хувирах, үнэ тариф нь хяналтаас гарах, хангамж нь эрсдэлтэй болох нөхцөл үүсэх талтай байна.

Найм. Газрын хэвлийгээ өлгийдөж хөгжлийг хангах

Монголын нутгийн хэвлий дор биднийгээ тэжээгээд байх байгалийн баялаг багагүй бий гэдэгт эргэлзэхгүй байна. Харин түүнийгээ зөв, ухаалаг ашиглах ёстой гэдэг дээр өнөөдөр ард түмний санаа бодол төвлөрч байна. Зарим нь бухимдаж байна. Энэ бухимдлыг ухаалгаар тайлж мэргэжлийн төвшинд олон дахин хэлэлцэж, зөв шийдэхийн төлөө төр засаг, ард түмэн, та бид бүгдээрээ ухаан санаагаа уралдуулж, ном хэвлэл үзэж, бусад орнуудын туршлага арга ухаанаас суралцахын төлөө зүтгэх хэрэгтэй болж байна. Миний бие өөрийн зарим санаа, дуулж сонссоноо төрийн зарим түшээдэд танилцуулсан. Хэлсэн үг санааг “цахим өртөө” веб байрлуулсан гэсэн. Монголын нутагт олдоод буй ашигт малтмал, эрдэс түүхий эдийн илэрцүүдийн байдлаас үзэхэд ирэх 30 жилийн туршид нүүрс, зэс, алт, мөнгө, төмөр, уран, фосфор зэргийг илүүтэй ашиглах боломж гарах төлөвтэй байна.

Сүүлийн жилүүдэд түүхий эд материалын (commodity)-ын үнэ, хэрэгцээ нэмэгдэж байна. Үүнийг Хятадад түүхий эдийн хэрэгцээ өссөн, нийлүүлэгч орнуудад гарч буй “итгэл” алдагдуулсан үйл ажиллагаа (Өрнөд, Лалынхны хоорондын сөргөлдөөн, Иракийн дайн, Ираны дайнд өртөх боломж, баялагтай орнуудад гарч буй жагсаал цуглаан, ажил хаялт, ОХУ-ын хуучин түншүүдтэйгээ зах зээлийн зарчмаар харилцах хүсэлт, түүнийг тойрсон улс төрийн тоглоом), түүнчлэн эрдэс түүхий эдийн олборлолтод хөрөнгө оруулалт цаг үеийн шаардлагаас хоцорсон зэрэгтэй холбон тайлбарлаж байна.

АНУ болон өрнөдийн зарим орнуудад сүүлийн жилүүдэд хийгдсэн эрчим хүчний хэлэлцүүлэгийн эцсийн үр дүн нь эрчим хүчний балансад эрчим хүчний хэрэгцээг газрын тос, нефтээр хангах үзэл давамгайлж байсныг өөрчилж, нүүрсийг эргэн ашиглах чиглэлд орлоо.

Зарим орнууд атомын эрчим хүчийг илүүтэй ашиглах зорилт тавьж эхэлж байна. Бидний амьдарч буй Британид хэдийгээр ард түмний эсэргүүцэл их байгаа ч гэсэн атомын цахилгаан станцуудыг сэргээх, шинээр барих, цөмийн эрчим хүчийг бий болгох талаар өргөн хүрээтэй хэлэлцүүлэг эхэлсэн.

Британид нүүрс, газ, атомын эрчим нийт эрчим хүчний хэрэглээний тус бүрдээ ойролцоогоор 30 орчим хувийг хангадаг бололтой юм билээ. Франц зэрэг орнууд эрчим хүчнийхээ ихэнхийг атомын цахилгаан станцаас гаргадаг. АНУ-ын нүүрснээс гадна атомын эрчим хүчийг ашиглах чиглэлээр тохиролцоонд хүрсэн. Үүнээс үзэхэд бид нүүрс, ураны баялагийн талаарх судалгаа, мэдээллээ гүнзгийрүүлж, бусад орнуудын өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангахад бэлэн байх хэрэгтэй байна. Нүүрсийг боловсруулж, хорт хий, утаа гаргахгүй болгож экспортлох шаардлага яваандаа тавигдах шинжтэй байна. Энэ нь бидэнд ч хэрэгтэй. Өмнөд Африк зэрэг нүүрсний нөөц ихтэй орнууд нүүрс цэвэршүүлэх, боловсруулах шинэ технологи нэвтрүүлж эхлээд байна.

Нүүрсний технологийн дэвшлийг Германи тэргүүлж буй ажээ. Манай хойт нутгаас эхтэй Оросын гол мөрнүүдийн усны нөөц холын ирээдүйд онцгой ач холбогдолтой болж мэднэ. Оросын усан цахилгаан станцуудын эрчим хүчний илүүдлийг Монголын нутгаар дамжуулан Хятадын өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэгцээг хангах явдал чухалд тооцогддог юм билээ. Цахилгааныг алс дамжуулсны шугамын алдагдлыг багасгадаг арга, технологи гарсан юм билээ.

Бид замаас нь юм уу өөрсдөө нүүрсний цахилгаан станц олныг барьж Хятад руу цахилгаан дамжуулан гаргах боломжтой. Гадныхан үүнийг сонирхож байдаг. Тааламжтай орчин хэрэгтэй. Монгол улсыг төрийн уламжлал сайтай, хоёр хөрштэйгөө хэзээ ч учраа олох орон гэдгийг гадныхан мэддэг байх аа. Эдгээрээс гадна бидний амьдрал, хувь заяанд онцгой нөлөө үзүүлж болох олон сайхан бүс нутаг, эрдэс баялаг байгаа бөгөөд эд бүгдийг бид дэс дараатай, зах зээлийн эрэлт, байршил, дэд бүтцийн хөгжил, боломжийг харгалзан ашиглана.

Бидний ирээдүй Та бүхэн, Та бүгдийн үр хүүхдийн гарт байна. Гагцхүү бид аливаад ерөнхийлөн, сэтгэлийн хөөрлөөр хандахгүй нарийн тооцоо судалгаатай, ул суурьтай, нэгэн сэтгэл, урам зоригтой хандвал хөгжлийн манлайд хүрнэ. 30 жилийн дараа Дэлхийн хамгийн том эдийн засаг Хятад байна гэж ярьцгааж байна. “Эдийн засаг” сэтгүүлд бичсэнээр Хятадын эдийн засаг худалдан авах чадварын

хэмжээгээр 2016 он гэхэд АНУ-ын эдийн засгийг гүйцэж түрүүлэхээр байгаа. Алтны дэргэдэх гууль шарлана гэдэг үгээр Монгол Улсын хоёр том хөрш хурдацтай хөгжиж, иргэдийнх нь худалдан авах чадвар дээшлэх тутам бидний хөгжлийн боломж нэмэгдэх бөгөөд үүнийг зөв ашиглаж, Монгол өөрийн гэсэн байр, үйлдвэрлэлийн баазыг бий болгож хөгжүүлнэ гэдэгт итгэлтэй байна. Ирээдүйгээ бодоход бидэнд өндөр мэргэжлийн, ялангуяа техникийн боловсрол сайтай, орчин үеийн шинэ техник, технологийг тайлж уншиж, ойлгож чаддаг, өөрийн болгох чадвартай болох нь чухал бөлгөө. Британид амьдралын ухааны сургалтыг цэцэрлэгийн наснаас эхэлдэг юм билээ. Бид үр хүүхдээ төрөлх хэл, амьдралын ухаанд сургах нь Монголын тусгаар тогтнолын бас нэг баталгаа.

Сайн үйлс дэлгэрч, нэг үе буюу 30 жилийн Монгол руу гэсэн сэтгэл, тэмүүлэл Дэлхий дахиныг дэлдэх болтугай.

МОНГОЛ ОРНЫ ХӨГЖИЛ: НЭГЭН ЭРИНИЙ ДОТОР

Ядам овогт Эрдэнэбаатарын Долгион

Өнөөдөр би та бүхэнтэй ирээдүйн талаар, монгол орныхоо ирээдүйн талаар, хамгийн гол нь бид хамтдаа бүтээн босголцож чадах тийм улсынхаа талаар ярилцахыг хүсэж байна. Юуны өмнө, энэхүү эрин үед, хүн төрөлхтөний амжилт хөгжил дэвшлээр дүүрэн ийм үед амьдарч байгаагаараа бид бахархах ёстой юм. Ийм алтан үед монгол хүн болж төрснөөрөө бид бахархах хэрэгтэй юм. Өнөөдөр бид 800 жилийн түүхтэй улс гүрний анх байгуулалцаж байсан өвөг дээдсийнхээ зөн билэг, хүсэл мөрөөдлийг дахин сэргээн эзэмшиж, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ёстой.

Жилээс жилд харилцаа холбоо, худалдаа нь үндэсний хил хязгаарийг үл хамаарах болж, хөрөнгийн урсгал бидний бодлыг үл дагуулахаар тийм хурдацтай шилжин, дэлхий нийтийн хөгжлийг тэргүүлэх өрсөлдөөн, үндэснүүдийн хооронд улам бүр ширүүссээр байна. Тийм эрин үед бидний монголчуудын дэлхий дахинд эзлэх байр суурь хаана байх ёстой юм бэ? Монголчууд бид, түүхийн хувьд, бусад улс үндэстний дээрээс өнгийн хардаг байсан гэдгээ хэсэг зуур умартаад, үнэн бодит хэрэгтээ эдүгээ бидний байр суурь яг хаана байна вэ гэж өөрсдөөсөө асуугаад үзэцгээе.

Өдгөө бид евроазийн цээжинд хоёр том хөршүүддээ бүүвэйлэгдэн нойрссон хэвээрээ л байна. Зарим эдийн засгийн өсөлтийн тоон үзүүлэлтүүдээр онц сурж буй мэт харагдавч, түүхийн тоосоо ч гүвээгүй, эгэл даруухан оршиж байна.

Өнөөдөр бидний 140 000 хүн ажилгүй, түүнээс ч олон монголчууд хоногийн хоолоо залгуулахын тулд өдөр, шөнөгүй ажиллаж байна. Мөн бидний монголчуудын бүхэл бүтэн 36 хувь нь ядуу хэмээн тооцогдож байна. Хэрэв Монгол улс хөгжиж байна гээд, монголчуудын амьдралын түвшин дээшилж байна гээд зөвхөн талхандаа санаа зовох шаардлагагүй хүмүүсийг жишээ татвал *нэгдүгээрт*, өрөөсгөл, *хоёрдугаарт*, инээдэмтэй хэрэг болох биз.

Монгол улс бол иргэд нь хайрлан бахархаж, ирсэн зочид нь суралцмаар тийм улс. Гэхдээ нэгэн тэнгэрийн дор бүх Монголчууд гэдэс цатгалан, оюун цэлмэг, санаа тэнэгэр алхаагүй цагт манай улсын хөгжлийг бүрэн төгс утгаар нь ярих боломжгүй. Засгийн газар ямар ч бодлого явуулсан, ямар ч гадаад бодлого, ямар ч батлан хамгаалах бодлого, ямар ч мөнгөний бодлого, ямар ч банкны бодлого явуулсан, жирийн монгол иргэдийн эрх ашгийг хамгаалж буй бодлого л хамгийн шилдэг бодлого байдаг гэдгийг санууштай.

Сүүлийн хэдэн арван жилийн турш эдийн засагчид нэг л асуултанд хариу олохын тулд толгойгоо гашилгасаар ирсэн. Тэр асуулт нь юу вэ гэхээр яагаад дэлхийн зарим улсууд эдийн засгийн хувьд өсөж хөгжөөд байхад бусад нь ядууралд автсан буурай хэвээрээ байдаг юм бэ? Монголд төдийгүй дэлхий нийтээр энэ талыг хамарсан олон тооны судалгаа хийгдэж байна.

Миний бодлоор Монгол улсыг хөгжүүлэх гол түлхүүр нь Дэлхийн банк, ОУВС юм уу хандивлагч орнуудын алинд ч бус, зөвхөн, жирийн монгол иргэдийн өдөр тутмын хандлагад л бий. Бид тийм чадвартай. Харин яг яаж? гэвэл юуны өмнө үндэсний зуршлаа өөрчлөхөд оршино.

Харвардын их сургуулийн WCIA (Weather Centre for International Affairs) төвөөс 1999 онд хийсэн улс орнуудын харьцуулсан судалгаанд нэгэн сонирхолтой жишээ байдаг. Энэ нь 1960 оны үеийн Өмнөд Солонгос болон Гана-ийн эдийн засгийн харьцуулсан үзүүлэлтүүд. Тухайн үед уг хоёр улсын нэг хүнд ноогдох ДНБ-ний хэмжээ, үйлдвэр үйлчилгээний салбаруудын хөгжил, экспортын онцлог болон авч байсан тусламжийн хэмжээ тун адилхан байсан. Харин гучин жилийн дараа Өмнөд Солонгос нэг хүнд ноогдох орлогын хэмжээгээр дэлхийд дээгүүрт орж автомашин

цахилгаан барааны дэлхийн томоохон экспортлогчдын нэг болсон байхад, Гана улс-Гана-аараа л үлдсэн байсан.

Энэ үед Өмнөд Солонгосын амжилтын нууцыг олох гээд, эдийн засгийн үзүүлэлтүүдэд эерэг нөлөө үзүүлж байсан хүчин зүйлс болон авч явуулсан эдийн засгийн бодлогуудыг нь судлаад байх тэр болгон шаардлагагүй юм. Улс орон болгонд нэг дозоор үйлчилсэн макро болон микро эдийн засгийн бодлого ч юм уу, хувьчлалын хэв загвар ч юм уу, гаднаас авах зээлийн хэмжээ ч байгаагүй. Харин бидний юуны түрүүнд анзаарах хэрэгтэй зүйл бол энэ судалгаанд хамгийн их дурдагдаж байсан үгсийг л ажиглах.

Thrift, savings, investment, hard work, self-discipline and education. Арвич хямгач байдал, хадгаламж, хөрөнгө оруулалт, уйгагүй ажиллах чанар, сахилга бат болон боловсрол.

Уйгагүй ажиллах, арвич хямгач байх, сахилга баттай байж эв нэгдлээ сахихад бидэнд гадны ямар ч зөвлөгөө тусламж шаардлагагүй. Бид тийм чадвартай. Маш бяцхан зүйлээс л эхлэцгээе. Жишээ дурдахад гэрлийн нэг лампаар солиход л 0,25 тонн нүүрс хэмнэнэ. Нэг айл хэдэн гэрлийн шилтэй билээ? Улмаар нийт улс даяар хэр их нүүрс хэмнэх вэ?

Мөн энэ 5 дугаар сарын 9-нд та бүхэн "Wall street journal"-ийн хуудаснаас бидэнд хэрэгтэй нэг зүйлийг мэдэж болно GE буюу General Electric болон Dow Jones-оос хамтран "Environmental bussiness plan challenge" гэж ердөө 50 000 ам.долларын шагнальтай уралдаан зарласныг харж болно. Харин шалгарч гарч ирж буй төслүүд дотор Lyle Parker-ийн төслүүд бий. Үндсэндээ нүүрсээр ажилладаг станцуудыг Melahn-ий технологиор тоноглогсны дараа үйлдвэрээс ялгарах хортой бодисын хэмжээг 95%-иар бууруулах төдийгүй үр дүнд нь устөрөгчийн хүчийг гарган авах боломжтой. Бид яагаад энэхүү технологийг нэвтрүүлж улмаар уг эрчим хүчийг ашиглаж болохгүй гэж? Бидний бололцоонд хязгаар үгүй. Ердөө төсөөлөөд л үз. Үнэхээр хязгааргүй.

Миний бас хувьдаа бодож явдаг нэг зүйл бол Англи болон Америкт хүмүүсийн Азийн таларх төсөөлөл, мэдлэг тийм ч гүнзгий бус юм. Энэ нь заримдаа нэлээн дээд түвшинд хүртэл мэдрэгддэг. Бид харин тэдний адил байх ёсгүй. Зөвхөн БНХАУ гэхэд л дөрөв юм уу, таван Америктай тэнцэхүйц хэмжээний зах зээл. Зөвхөн Бээжингийн Олимпийн тоглолтонд гэхэд л Хятад 45 тэрбум ам.доллар зарцуулж

байна гээд бодоод үз. Хятад, мөн дээр нь Энэтхэгийг нэмэхэд бидний хаяанд дэлхийн гуравны нэгтэй тэнцэхгүйц зах зээл бий гэж үзэхүл бид Европын холбоо АНУ бус харин хаяанаасаа эхлэн дэвшингуй бодлого явуулах нь илүү ухаалаг болох юм.

Бидэнд өгөөжтэй байхаар, мөн амжилт олохуйц ямар салбаруудыг дурдаж болох вэ? +Эм зүй (capacity), Химийн салбараас (capacity) эхлээд дээд түвшинд бэлтгэгдсэн мах болон хүнсний үйлдвэрлэл. (capacity)+ (capacity)+Бидэнд чадвар байна. Гагцхүү түүнийгээ ашиглах л үлдлээ.

Хөгжихийн тулд бид бодит байдлыг үнэнээр нь хүлээн зөвшөөрч, биднийг сулруулж буй асуудлуудтайгаа тэмцэх хатуу бодлого барих хэрэгтэй байна. Өнөөдрийг өнгөрөөж, маргаашийг аргацаасан, сонгуулиас сонгууль дамжсан, нэг сайдаас нөгөө сайдыг хүлээсэн сэтгэхүй хэзээ ч бидний сонголт байх ёсгүй.

Өнгөрсөн зууны эхээр Theodore Roosevelt хэлсэн байдаг. "The one characteristic more essential than any other is foresight... it should be the growing nation with a future that takes the long look ahead". Нэг ёсондоо "холыг харсан үндэстэн л өсөн дэвжих жамтай" гэсэн үг.

АНУ үргэлжид одоогийнх шиг ийм хүчирхэг байгаагүй. Зуун жилийн дараа эдүгээ, Рузвельт-ийн удирдаж байсан улс ямархуу дайтай явж буйг та бид сайн харж байна. Холыг харж алсуур төлөвлөж байж л бид улсын хэмжээний, үндэстний хөгжлийн түүхийг бүтээнэ. Бидний сурах ёстой улсуудаас хамгийн түрүүнд мэдээж АНУ орно. Гэхдээ залуучууд, боловсон хүчнээ Америк луу олноор явуулж байя гэдэг үүднээс бус харин тэдний боловролын тал дээр авч хэрэгжүүлж буй, бүүр цаашлаад авч хэрэгжүүлэх гэж буй бодлогыг бид микроскопоор харах шаардлагатай байна.

Хэрвээ АНУ-ыг дэлхийн хамгийн хүчирхэг улс гээд тооцвол энэ хүчирхэг гүрний титмэн дээрх хамгийн өнгөлөг чулуунууд нь Эрх чөлөөний хөшөө бус Ерөнхийлөгчийн онгоц ч биш, харин америкийн судалгааны институтууд болон их сургуулиуд нь байдаг. Түүхийн үүднээсээ нэн сурууштай нь америкчууд хэзээ ч нэг зүйлд сэтгэл цадаад орхидоггүй. ЗХУ анхалж Спутник-ийг хөөргөсний дараа тэд боловсрол болон шинжлэх ухааны байгууллагуудыг тэргүүлэх хэмжээнд тавьж эхэлсний үр дүн нь саран дээр анх хүн төрөлхтөн хөл тавьсан аялал байсан.

Та бүхэн хэрвээ санаж буй бол энэ оны нэг сард Ерөнхийлөгч Жорж Буш, Конгрессын хамтарсан хуралдаанд тавьсан илтгэлдээ ACI буюу "American

competitiveness initiative" нэртэй 10 жилийн 136 тэрбум ам.долларын өртөг бүхий хөтөлбөр дэвшүүлсэн. Дээд боловсролын чанарыг сайжруулах, физик математик, инженерийн салбарын шинжилгээ судалгаа болон дэд бүтцийг өргөжүүлэх, багш нарыг бэлтгэх, боловсон хүчнийг мэргэжлийн үүднээс дэмжих нь энэ хөтөлбөрийн гол зорилго юм. Ерөнхийлөгч Буш энэ талаар ярих тэр мөчид би яг юуг харсан бэ гэвэл Академич ертөнцөд дахин Америкийн тавин жилийн ноёрхол, дахин Америкийн тавин Нобелийн шагналтан.

Бид үүнээс сонсох бус жишээ авах ёстой. Бидэнд ийм чадвар бий. Хэрэв Америкчууд дээд боловсролоос эхэлж байвал бид дээд болон дунд боловсролоос, хэрэв хятадууд түүнийг хийж байвал бид дээд, дунд боловсролоо цэцэрлэгийн наснаас эхлэн бодлоготойгоор тэргүүлэх хэрэгтэй. Бидэнд тийм чадвар бий.

Баруунд бараг хүн болгон Чингис хааныг мэддэг. Монголыг газрын зураг дээр олж чадахгүй хүмүүс хүртэл Чингис хааны талаар, түүний амжилтын талаар сонссон байдаг. Харин бид үргэлж түүхийн алтан үе гэж ярихын өмнө санаж байх ёстой зүйл бол хааны хувьд одоо Чингис байхгүй ч гэлээ гений хувьд бид одоо хүртэл Чингистэйгээ байна. Түүхийг бид бичилцэх учраас түүх бидний талд байх болно. Би хувьдаа Чингис хааны үед монголчууд хэрхэн тийм агуу зүйлсийг бүтээж байсан бэ гээд бодоход ердөө хоёрхон зүйлд итгэснээр тийм агуу байж чадсан. *Нэгдүгээрт*, хувь хүн бүр өөрийн хариуцлагаа ухамсарлаж ойлгож чадсанд, *хоёрдугаарт*, хамтдаа өнөөдрөөс маргааш ихийг бүтээнэ гэж зорьсонд. Тэр үед монголчууд илүү ухаантай байсанд бус,, тэр үед дэлхийн улс үндэстнүүд сул дорой байсанд ч бус,, харин бид хамтдаа сэтгэж чадсанд л гол хүч чадал агуулагдаж байсан. Эдүгээ ч тийм л байх болно.

Монгол хүн болгонд олгох боломж өргөн, монгол хүн бүрээс хүлээх хариуцлага өндөр, монгол хүн бүгдийн хооронд эв нэгдэл хүчтэй байж л та бидний оюунд орших Монгол улс амьдралд биелэлээ олно, нэгэн эриний дотор, бидний эринд. Би яриагаа нэгэн хэвийн болсон мэт биеэ засаад гэрээ зас, гэрээ засаад төрөө зас гэж дуусгамааргүй байна. Төр төвшин бус бол миний гэр хичнээн сайхан байгаад ч яах юм билээ. Бид биеэ засах гэж хичнээн ч удах юм билээ? Хэрвээ улсаа хөгжүүлэе, дэлхийд "Монголын хөгжлийн гайхамшиг" гэсэн нэр томъёог оруулъя гэвэл яагаад бүгдийг нь зэрэг бүтээж болохгүй гэж? Үнэхээр ч бидний өмнө тулгарсан сорилтууд-**сүрдмээр**,, гэсэн хэдий ч бид, монголчууд- **сүрдмээр**,, аугаа

үндэстэн. Бид хичээнгүй, уйгагүй, мөн ирээдүйдээ итгэл төгс бүхий тийм үндэстэн. Тийм ч учраас аугаа үндэстэн шиг зөгнөж, аугаа үндэстэн шиг сэтгэж, аугаа үндэстэн шиг үйл хэрэгээ бүтээцгээе.

Монгол орон мандан бадраг.